



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/476

Чингис хот

Тусгай зөвшөөрлийн комиссыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", 29.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2015 оны 298 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам"-ын дагуу Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссыг шинэчлэн байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Комиссын ажиллах журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга (Л.Мэндбаяр)-д үүрэг болгосугай.

3. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн "Тусгай зөвшөөрлийн комисс байгуулах тухай" А/476 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:	Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга
Гишүүд :	Г.Лхагвахатан	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Д.Наранмичид	Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга
	С.Хэнчмэдэхгүй Н.Бадрангуйтөгс	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга Мэргэжлийн Хяналтын газрын эм Биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч
	Ц.Болортуяа	Эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм холбоо” Төрийн бус байгууллагын Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүн
Нарийн бичгийн дарга:		Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга